

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/397 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар, “Даланзадгадын дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГ-т худалдах дулааны тарифыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс, гуравдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК (Д.Эрдэнэтөгс), “Даланзадгадын дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГ (Б.Мөнх-Амар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 521 дүгээр тогтоол, 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 132 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, “Тариф батлах тухай” 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 541 дүгээр тогтоолыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	3,200.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	49,882.4
		Тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,994.7

-оОо-

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА  
БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	3,200.0
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 49,882.4
		Тогтмол	Төг/м <sup>3</sup> 1,994.7
3	Орон сууцны халаалт (дотуур байр, подваль, "00"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	1,400.0
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	Төг/хүн 1,870.0
		Халаалтын бус улиралд	Төг/хүн 2,806.0
5	Дулааны үйлчилгээний төлбөр	40 м2 хүртэл талбайтай айл өрх	Төг/сар 3,300.0
		41-80 м2 хүртэл талбайтай айл өрх	Төг/сар 5,500.0
		81 м2-с дээш талбайтай айл өрх	Төг/сар 11,000.0

-оОо-

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2023 оны ... дүгээр сарын ...-ний өдрийн  
... дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

**“ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ААС  
“ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-Т ХУДАЛДАХ  
ДУЛААНЫ ТАРИФ**

1. Худалдах дулааны тариф (НӨАТ-гүй)-ыг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

<b>№</b>	<b>Ангилал</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тариф (НӨАТ-гүй)</b>
1	“Даланзадгадын дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГ-т худалдах дулааны тариф	Төг/ГЖ	<b>47,412.0</b>
		Төг/Гкал	<b>198,510.4</b>